

**МОНГОЛ УЛСЫН ШАШИН ТӨРД ТУСЛАХ САЙДЫН ЭРХ ХЭМЖЭЭГ
ТОДРУУЛАХ НЬ (1912-1915)**

Г.БАЯРМАА

Товч агуулга: 1911 онд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж VIII Богд Живзундамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанд өргөмжлөн, таван яам¹ бүхий Засгийн газрыг эмхлэн байгуулсан билээ. 1912 онд засгийн газрынхаа бүтэц зохион байгуулалтыг өргөтгөн шинээр гурван яам² байгуулсны нэг нь Шашин төрд туслах сайдын газар байлаа. Монголын түүх бичлэгт Шашин төрд туслах сайдын газар гэгчийг байгуулсан явдлын шалтгааны талаар судлаачид өөрсдийн саналыг дэвшүүлэн бичиж тэмдэглэсэн зүйл байх боловч тухайн институцын статус ямар байсан, тухайлбал газар яам байсан уу? эсвэл сайдын газар байсан уу?, мөн түүнчлэн үйл ажиллагаа, эрх үүрэг, хийгээд түүний болон Их шавийн эрдэнэ шанзудбын яамны харилцан хамаарлын талаар тухайлан судлан үзсэн нь одоо хир үгүй байна.

Тиймээс энэхүү өгүүлэлд Шашин төрд туслах сайдын газар байгуулагдсан хийгээд татан буугдсан, үйл ажиллагаа эрх үүрэг зэргийг тодруулахыг зорив. Чингэхдээ Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй Шашин төрд туслах сайдын яам болон бусад яамдын данс хараанд хадгалагдаж буй эх сурвалжуудыг ашигласан болно.

Түлхүүр үг: Живзундамба, Эрдэнэ шанзудба, Шашин төрд туслах сайдууд, яам, бүтэц, үйл ажиллагаа

Оршил

1912 онд Монгол улсын засгийн газар бүтцээ шинэчлэн гурван яамыг нэмэн байгуулсны нэг нь Шашин төрд туслах сайдын газар юм. Төрийн байгуулалтанд ийнхүү шинэтгэл хийсэн явдлыг судлаачид,

¹ Дотоод хэргийг Бүгд захиран шийтгэх яам, Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яам, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яам, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яам, Шүүн таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам

² Бүгд Ерөнхийлөн захирах яам, Гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам, Шашин төрд туслах сайдын газар

- Монголын томоохон нөлөө бүхий алтан ургийн хар ноёд, томоохон лам нарын зөрчлийн улмаас³ хэмээн тайлбарлаж бичсэн нь нэлээд түгээмэл байна. Ийнхүү бичсэн судлаачид зөрчлийн шалтгаан нь Монгол улсын хааны сэнтийд шашны хүн заларсан явдал хийгээд, түүнийг хүрээлсэн лам нарын гэх бүлэглэл төрийн эрхэнд гарч ирснээр тайлбарладаг. Тухайлбал, анх байгуулагдсан таван яамны дэсийг тогтооход Дотоод яам бусад яамнуудаа тэргүүлэхээр заасан бөгөөд тус яамыг да лам Цэрэнчимид толгойлох болсон явдлаас үүдэлтэй хар ноёд үүнд нь дургүйцэх болсон гэж бичсэн байна. Монголын ихэс дээдсүүд хар, шараараа талцах болон угсаа гарвалаараа ялгаран хэсэг бүлэг болсон явдал байсан нь тус оронд улс төрийн бүлэг, бүлэглэл бий болж байсан хэмээн үздэг түүхч, судлаачид цөөнгүй байна.
- Гэтэл дээрх үзэлтээс өөр байр суурь илэрхийлж бичсэн судлаачид 1912 онд тийнхүү Бүгд ерөнхийлөн захирах яам зэргийг байгуулсан явдал нь Монгол төрийн бүтцээ төгөлдөржүүлэх⁴ үүднээс ерөнхий сайдын албан тушаалыг буй болгож, төрийн байгуулалтанд шинэчлэл хийсэн гэж үзээд, эл явдал нь монголын улс төрд лам нар илүү эрх дархтай болсны улмаас хар, шар ноёдын зөрчилдөөн ихээхэн хурцадсаныг намжаах зорилгоор хийгдсэн зүйл биш юм хэмээн түүхч З.Лонжид үзсэнд, түүхч Ж.Урангуа тал өгч бичсэн нь бас байна.

Ингээд Олноо өргөгдсөний хоёрдугаар оны намрын сүүл сарын 15-нд Дотоодын зэрэг олон яамны хамаг хэргийг бүгд ерөнхийлөн захирах сайдаар Сайн ноён хан Т.Намнасүрэнг тохоон томилж, тамгыг нээн хэрэглэх зөвшөөрөл олгосны нэг хоногийн өмнө Шашин төрд туслах сайдын тушаалыг буй болгож түүнд Эрдэнэ Шанзудба Бадамдоржийг томилж, улмаар дэд сайд буюу эрхлэн зөвлөх сайдын

³ Г.Дашням. Монгол улсын шашин төрд туслах сайдын яам, түүний үйл ажиллагаа. - 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд лам нарын оруулсан үүтгэл үйлс. МБШТ Гандантэгчэнлин хийдээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар: 2011; Р.Төрбат. Монгол улсын Шашин төрд туслах сайдын яамны түүхийн асуудалд. *Acta historica* XVI. F.11. 2015; Л.Дэндэв. Монголын товч түүх. Улаанбаатар: 2014; С.Пүрэвжав. Монголын шарын шашны хураангуй түүх. Улаанбаатар: 1978; С.Пүрэвжав *Хувьсгалын өмнөх Их хүрээ*. Улаанбаатар: 1961; Г.Навааннамжил. *Өвгөн бичээчийн өгүүлэл*. Улаанбаатар: 1956; *Галсангийн Навааннамжилийн бүтээлийн дээжис*. Улаанбаатар: 2011; Ш.Сандаг. *Монголын улс төрийн гадаад харилцаа \1850-1919*. Улаанбаатар: 1971; Ш.Нацагдорж. *Монголын Феодализмийн үндсэн замнал*. Улаанбаатар: 1978; Ж. Болдбаатар. *Монголын 1911 үндэсний хувьсгалын зүтгэлтнүүд*. Улаанбаатар: 2011 гэх мэт

⁴ З.Лонжид. Монголын гурван хувьсгал ба лам нар. - *Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал*. Улаанбаатар: 2002, 183; Ж.Урангуа. *Монголын бүрэн эрхт байдал, төрийн байгуулалтын асуудал \1911-1919*. Улаанбаатар: 2011, 25.

тушаалд да лам Дашжавыг тохоон томилсон байна. Ингэж Монгол улсын төрийн бүтцэнд нэгэн шинэ байгууллага буй болж 2 жил гаруй үйл ажиллагаа явуулсан юм.

Шашин төрд туслах сайдын газар байгуулагдсан ба бүтэц зохион байгуулалт

Сайдуудыг томилсон нь

1912 онд Монголын засгийн газар бүтэц зохин байгуулалтдаа өөрчлөлт оруулан гурван яам нэмэн байгуулсаны нэг нь Шашин төрд туслах сайдын газар юм. Энэхүү байгуулалтыг Олноо Өргөгдсөний хоёрдугаар оны \1912\ намрын сүүл сарын 14-нд \10-14\ Богд хааны зарлиг бууж, “...Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудбад Шашин төрд туслах сайдын тамга олгож тушаал дараалан хэрэглүүлж шажин төрийн хэрэгт чухал эрхэмлэн айлтгаваас зохихыг шууд айлтгаж явахыг үүрд дагаж шийтгэгтүн”⁵ хэмээсэн ёсоор Шашин төрд туслах сайдын албан тушаалыг буй болгож, түүний эрхлэх ажлыг заан өгчээ. Энэ баримтаас үзэхэд тус сайдын үйл ажиллагаа нь шашин ба төрийн гэсэн хоёр чиглэлтэй байхаар заажээ.

Богд хааны лүндэнг Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамнаа шилжүүлэн: ...Эрдэнэ шанзудбад олгох сайдын тамгыг хурдан түргэн цутгууж шагнан олгоход бэлтгүүлсүгэй. Очир дарь эзэн гэгээний мутарт өргө⁶ хэмээсэн ёсоор Намрын сүүл сарын 24 –нөө дээрээс шавь боол Ба⁷-г дуудан авч мутраар шагнан Нийслэл Хүрээний Эрдэнэ шанзудбад тамгыг хүлээлгэн залж авсан даруй. Дээрхийн хишигт мөргөн тамгыг мөнхүү өдөр нээн хэрэглэжсүхүй⁸ хэмээн Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудбад Шашин төрд туслах сайдын тамга шагнаж үүрд сайдын албыг хавсарган хаалга⁹ гэсэн байна. Дээрх баримтуудаас үзэхэд Богд хааны лүндэн буусны дараа 10 хоногийн дотор тамга цутгаж, олгоход бэлтгүүлэн 24-ний өдөр тамгыг нээн, сайд ажилдаа орсон бөгөөд Бадамдорж нь Их Шавийн Эрдэнэ шанзудба болон Шашин төрд туслах сайдын албыг “хавсран”, чингэхдээ “үүрд” хэмээн заасан байх аж.

Шашин төрд туслах сайдыг томилсноос хэдхэн хоногийн дараа Олноо Өргөгдсөний хоёрдугаар оны \1912\ өвлийн дунд сарын шинийн 6-нд Шашин төрд туслах сайдад эрхлэн зөвлөх сайдын орыг бий болгон, ...Нийслэл хүрээний Да лам нарын дотроос сонгон томилж байхаар тогтож да лам Дашжав нэнсү

⁵ МУУТА. А-3 Д-1 ХН-324, нугалбар 33

⁶ МУУТА. А-3 Д-1 ХН-324, нугалбар 33

⁷ “Ба” буюу Бадамдорж тэрээр 1903 оноос 1915 хүртэл Их шавийн Эрдэнэ шанзудбын яамыг тэргүүлж байсан.

⁸ МУУТА. А-74 д-1 ХН-813, нугалбар 4

⁹ МУУТА. А-9 Д-1 ХН-1, 10-13

билэгт-ийг Эрдэнэ шанзудба Шашин төрд туслах сайдад эрхлэн зөвлөх сайдын тушаалд тохоон тавьж яамны дэд сайдуудын ёсоор явуул¹⁰ хэмээн тохоон тавьсан байна. Энд дэд сайдын ёсоор явуул гэж заасанд тухайд холбогдуулан тэмдэглэхэд, Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичигт: “Дэд сайдад олон аймаг, шавийн хан, вангаас доош гүн, да лам нараас дээш түшмэлийг сонгож тавь”¹¹ гэж заасан байх бөгөөд мөн Их шавийн яаманд эрдэнэ шанзудба нэг, хоёр да лам байх ёстой байсныг харгалзан үзвээс Их Шавийн хоёр да ламын нэг нь энэхүү шинээр буй болгож буй сайдын эрхлэн зөвлөх сайдаар томилогдох боломжтой болжээ. Өөрөөр хэлвэл Эрдэнэ шанзудбын яамны хоёр том тушаалтан төрийн хэрэгт зөвлөх эрхтэй болсон байна. Хуулинд зааснаар эл үед Их Шавийн өндөр албан тушаалтнуудыг томилоход Дотоод яамаар дамжин Богд хаантанд уламжилдаг байсан нь онцлог юм.

Сайдын ажлын албаны бүтэц, орон тоо

Үндсэний Төв Архивд тус газрын сайд болон дэд сайдын албан тушаалд хэн хэнийг томилсон тухай лүндэн байх боловч тус сайдын ажлын албаны газрын бүтэц зохион байгуулалт хийгээд орон тоо хууль эрх зүйн актанд тусгагдаагүй, бидэнд тодорхойгүй байгаа боловч тус яамны албан бичгүүдийг нягтлан судлан үзэж, тодруулах боломж байна.

Ингээд тус яамны тэргүүн сайд болон эрхлэн зөвлөх сайд нар ажлын албаа 1913 оны эхээр эмхлэн байгуулжээ. Шашин төрд туслах сайд Бадамдоржоос 1913 онд Бүгд Ерөнхийлөн захирах, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яам болон Сангийн хэргийг бүгд захиран шийтгэх яаманд өргөсөн нэгэн бичигт тус яамын орон тоо, бүтцийн тухай ийнхүү өгүүлсэн байна. Энд ... Ноднин жил\1912\ есөн сард Эрдэнэ Шанзудбад Зарлигаар Шашин Төрд Туслах Сайдын-ын тамга шагнаж 11- сард нээж билэгт Да лам Да –г Эрхлэн зөвлөх сайд тавьж олон яамны дэд сайдын хууль ёсоор явуулах учир зарлиг байгуулсныг хичээнгүйлэн дагаж айлтган явуулах хэрэг зүйлийг эрхлэн шийтгэхэд эх зохиох түшмэл, бичээч 2-ыг цаг цагаар томилон авч алба хаалгах¹², мөн өөр нэгэн баримтад “Магсаржав, Майдаржав, Бат-очир¹³ гэх гурван эх зохиогч түшмэл, жинхэнэ бичээч 4, галч¹⁴ гэж дурьдсанаас

¹⁰ МУУТА. А-9 Д-1 ХН-1, 14-16

¹¹ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Зургаадугаар дэвтэр. Түшмэл байгуулах тушаал хууль. Улаанбаатар: 2010, 47

¹² МУУТА. А-9 Д-1 ХН-4, нугалбар 62

¹³ Мөн тэнд

¹⁴ Төрбат, Р. Монгол улсын Шашин төрд туслах сайдын яамны түүхийн асуудалд. *Acta historica* XVI. F.11. 2015, 221.

үзэхэд сайд, дэд сайд, эх зохиох түшмэл, жинхэнэ бичээч, бичээч, галч гэсэн орон тоотойгоор тус сайдын газар үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Энэхүү газрын бүтэц орон тоог бусад яамдын орон тоотой харьцуулж үзвээс: Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яаманд ...тэргүүн сайд нэг ор, дэд сайд 2 ор, эрхэлсэн түшмэл 1ор, дэс түшмэл 2 ор, харъяат яамнаас эрхэлж тохоож, эх зохиогч түшмэл 6 ор, жинхэнэ бичээч 10 ор, яамны сав хэрэглэлийг эрхлэх, сахин нярав нэгэн ор, хаалганы дарга нэг ор, зарлага 7 ор, хаалга сахигч 4 ор, галч 4 ор, цэргийн зэр зэвсгийг дааж шийтгэх түшмэл нэгэн ор бичээч нэгэн ор, сахих хадгалах дарга нэгэн ор хуяг найман ор¹⁵ гэсэн орон тоотой ажиллаж байжээ. Эндээс харвал Шашин төрд туслах сайдын газрын орон тоо, бүтэц цомхон цөөн байсан байна.

Шашин төрд туслах сайдын тамга

1911 онд байгуулсан 5 яамны бүтэц том байсан ба тамга нь Яам гэсэн бичигтэй тухайлбал, Сангийн хамаг хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тамга, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамга г.м. Манай судлаачид 1912 онд шинээр 3 яам нэмж байгуулсан хэмээн бичдэг. Гэтэл энэхүү шинээр байгуулсан гурван газар нь Сайд хэмээсэн тамга хэрэглэж байсан байна. Тухайлбал, бидний авч үзэж буй газрын тамга нь “Нийслэл Хүрээний Эрдэнэ Шанзудба \дундаа соёмботой\ Шашин төрд туслах сайдын тамга” гэсэн дардастай, харин Гаалийн яам “ Гаалийн хэргийг ерөнхийлөн захирах сайдын тамга” гэсэн байна (анх байгуулагдсан 5 яам бүгд ижил-Г.Б.). Яамны тамга болон сайдын тамга гэсний хооронд нэлээд ялгаа байх учиртай хэмээн үзвээс бидний авч үзэж буй сайдын газар нь яамны зиндаанд хүрэхүйц орон тоо, бүтэц үгүй бөгөөд түүнд онцгойлон хамаарч эрхлэх салбар байсангүй, гагцхүү урдын адил Эрдэнэ шанзудбагийн алба ерөнхийдөө шашны хэргийг эрхлэх боловч шашны зарим хэргийг Дотоод яам бас хариуцах бөгөөд тамгатай хутагтуудын хэргийг хутагтууд өөрсдөө эрхлэн шийтгэж явуулж байсан байдаг. Бүх яам Бүгд ерөнхийлөн захирах сайдын яамтай зөвшилцөн шийдвэр гаргаж Богд хаанд өргөн барьж, тэрбээр улаан бийрээр цохвоос хэрэгждэг журамтай байсан билээ. Үүнийг тухайн үед “*нийлж хувьсан тогтоож, айлтгаад*” гэж бичсэн байдаг.

¹⁵ Ж.Урангуа. *Монголын бүрэн эрхт байдал, төрийн байгуулалтын асуудал \1911-1919*. Улаанбаатар: 2011, 33.

Шашин төрд туслах сайдын газрын эрх хэмжээний асуудалд

Бүгд ерөнхийлөн захирах сайдын яам, Гаалийн хэргийг ерөнхийлөн захирах газрын албан бичиг баримтууд “яам”-наас хэмээсэн тодотголтой явуулдаг байсан бол Шашин төрд туслах сайдын баримт бичгүүдэд “яам” гэсэн нэршил байхгүй зөвхөн *Шашин төрд туслах сайдуудад илгээв, Шашин төрд туслах сайдууд танаа өргөв, Шашин төрд туслах сайдуудын бичиг, Шашин төрд туслах сайд Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба Эрхлэн зөвлөх сайд Да ламын бичиг* хэмээн цохон тэмдэглэсэн баримт бичгүүдээр бусад яамд олон газруудтай харилцдаг байжээ. Энэ нь Богд хааны зарлиг ёсоор “Шашин, төрийн хэргийн дотроос эрхэмлэн айлтгаваас зохихыг шууд айлтга” хэмээсэн ёсоор эзэн хаантай шууд харилцах эрхтэй байжээ.

Шашин төрд туслах сайдын зэрэг дэвийг тогтоохдоо Шашин төрд туслах сайд Эрдэнэ шанзудбыг Бүгд ерөнхийлөн захирах зэрэг зургаан яамны тэргүүн сайдуудын даргаар жагсааж аливаа хурал ном ба албаны газар ёслох жагсах хурах суух зэрэгт цөм энэ ёсоор дагаж явуулагтун¹⁶ хэмээсэн дээдийн зарлиг гарсан нь энэхүү сайдын газар нь бусад яамдаас зэрэг дэв доогуур байсны илрэл юм. Мөн эрхлэн зөвлөх сайд нь ноёдуудын жагсаалд зэрэг дэвийн хувьд бусад яамдын дэд сайдуудын хууль ёсоор жагсдаг байсан. Энэхүү газар нь бусад яамдуудаас зэрэг дэвийн хувьд доогуур байсанг судлаач Г. Дашням Монгол улсын шашин төрд туслах сайдын яам, түүний үйл ажиллагаа илтгэлдээ¹⁷ тодорхой гаргаж тавьсан билээ. Тэрээр олон газруудтай харилцсан бичгүүдийн хүндэтгэлийн үгэн дээр ажиллаж, ийнхүү дүгнэсэн байна. Шашин төрд туслах яам нь зэрэг дэсийн хувьд бусад яамдаас доогуур боловч энэ яамны сайдын эрх хэмжээ, нэр нөлөө бусад яамдаас доогуур гэсэн хэрэг биш юм. Шашин төрд туслах яам нь төрийн эрхэнд дээд лам нарын байр суурийг бататган бэхжүүлэх зорилгоор байгуулагдсан¹⁸ гэж түүхч Г.Дашням бичсэнтэй миний бие санал нэг байна. Гэхдээ Г.Дашням Шашин төрд туслах яам хэмээн бичсэн байна. Би энэ газар нь яам биш, харин дээд лам нараар толгойлуулсан шашны хэргийг голлон эрхлэсэн төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, санал оруулах эрх бүхий сайдын газар байжээ хэмээн үзэж байна.

¹⁶ МУУТА. А-9 Д-1 ХН-6 218-219 тал

¹⁷ Дашням, Г. Монгол улсын шашин төрд туслах сайдын яам, түүний үйл ажиллагаа. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд лам нарын оруулсан үүтгэл үйлс. *МБШТ Гандантэгчэнлин хийдээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл*. Улаанбаатар: 2011, 3.

¹⁸ Мөн тэнд, тал 3

Я.Цэвэл 1963 онд туурвин гаргасан Монгол хэлний товч тайлбар толинд “яам” гэдэг үгний тайлбарт 2 утгын талаар бичихдээ, “аливаа нэг тухайлсан хэргийг хариуцсан улсын хэмжээний төвлөн захирах захиргааны том газар: Хөдөө аж ахуйн яам, Сангийн яам” гээд мөн цааш нь “Элчин сайдын яам (а. Элчин сайд тэргүүтэй дипломат төлөөлөгчийн газар, б. Мөнхүү төлөөлөгчийн албан хэрэг явуулах байр, жишээ нь- элчин сайдын яаман дээр очоод ирлээ)” гэсэн байна. Бидний өгүүлж буй Шашин, төрд туслах сайдын газар нь чухам дээрх тайлбарын хоёрдахид заасан зүйлтэй ижил юм.

1914-1919 онуудад хуралдаж байсан Улсын Дээд, Доод хурлын дүрэмд зааснаар тус газрын хоёр сайд Дээд хуралд сууж улс орны бүхий салбарт холбогдох асуудлыг хэлэлцэх ажилд оролцож байжээ. Архивын нэгэн баримтанд:”...цагаан сарын 14-ны Дүйчин өдөр Нийслэл хүрээний Хамба номун хан, Эрдэнэ шанзудба, Да лам нар олон орон сүм дацанд мөргөл хийх учир манай Шашин төрд туслах сайд Эрдэнэ шанзудба, Эрхлэн зөвлөх сайд Да лам нарт энэ өдрийн хурлын чөлөө олгох ажаамуй¹⁹ гэсэн байх бөгөөд төрийн ажил, шашны ажил нь давхцах явдал гарч байсан бололтой.

Шашин төрд туслах сайдын газар албан хаагчдын цалинг 1912 оны 9 сараас 1913 оны 12 сар хүртэл Эрдэнэ шанзудбын яамнаас ...тамга барьсан сайдуудад Эрдэнэ шанзудбын хувь жил бүр олгох хүнс мөнгө 500 ланы дээр сайдын тушаалын хувь хэрэглэл нэмж олгох эсэхийг заан тогтоох, ... Эрхлэн зөвлөх сайд Да лам –д нэг жилийн хэрэглэл хэмээн 300 лан эх зохиох түшмэлд хүн тутам өдөр бүр наймаад цэн, бичээч зургаан цэн, мөнгө²⁰олгож байсныг Бадамдоржоос Бүгд Ерөнхийлөн Захирах Яам, Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яам, Сангийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамуудад айлтган ...Зарлигаар Шашин төрд туслах сайд тавьсан нь тушаалын хувь учир ялгавар болохын дээр мөн Эрхлэн зөвлөх сайдыг олон яамын дэд сайдын хууль ёсоор явуулсны тул олон дэд сайдуудын адил өдөр бүр 6 ланы хэрэглэл олгуулж болох эсэх басхүү түшмэл бичээч нар мөнхүү олон яамны түшмэл бичээч нарын адил хэрэглэл олгуулахыг хүсэх нь буй ... манай Шашин төрд туслах сайдуудад Эрхлэн зөвлөх сайд Да лам ба түшмэл бичээчид хичнээн хэрэглэл олговоос зохихыг нэг мөр болгон тогтоож энэ өвлийн дунд сараас эхлэн олгуулваас зохих хэрэглэлийг цаг дараалан Улсын сангаас тавин олгуулах ажаамуй хэмээн үүний тулд өргөн илгээв²¹ хэмээн

¹⁹ МУУТА. А-1 Д-1 ХН-27

²⁰ МУУТА. А-9 Д-1 ХН-4, нугалбар 62

²¹ МУУТА. А-9 Д-1 ХН-4, нугалбар 62

айлтгасан зэргээс үзвэл энэхүү газар нь Эрдэнэ шанзудбын яамны суурин дээр байгуулагдаж²² сайд нь Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба, Шашин төрд туслах сайдын албыг хавсран эрхэлж, түүний эрхлэн зөвлөх сайдад Нийслэл хүрээний Да лам нарын дотроос нэгийг сонгон айлтгаж томилогдох журамтай байсан²³ нь чухамдаа Богд хаан өөрийн мэдлийн Их шавийн хамаг хэргийг эрхлэн шийтгэх Эрдэнэ шанзудбын яамыг хэрэг дээрээ Монголын шашны асуудлыг эрхлэн мэдэх төвлөрсөн байгуулга болгон өргөжүүлж, шашны асуудлуудыг хаанд эрхэмлэн айлтгахын сацуу төрд зөвлөх эрхтэй байгуулгыг шинээр бий болгосон байна.

Шашин төрд туслах сайдын газрын үйл ажиллагааны чиглэл

Их хүрээний Эрдэнэ шанзудбын яамыг түшиглэн байгуулагдсан энэхүү сайдын газар Монголын шашны асуудлыг ерөнхийд нь эрхлэн мэдэх байгууллага болсон хэдийч Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яам болон Бүгд Ерөнхийлөн Захирах яамтай хамтран Монголын шашны асуудлыг хамтатган мэдэж байсан нь архивт хадгалагдан буй баримтуудаас тодорхой байна. Тиймээс үйл ажиллагааны чиглэлийг тодруулахад дараах дүр зураг гарч байна. Үүнд:

Шашны хүрээнд эрхлэн шийдвэрлэж байсан асуудлуудыг дүрэм хэмжээ ёсоор зааж өгсөн ба энд ... ургаш олон хутагтын зэрэг лам нарт гавъяа буй агаад тусгайлан Богд эзний хишиг гуйн айлтгаваас зохихыг нь байх буюу сүмд нэр шагнуулахыг гуйх хэргийг цөм Нийслэл Хүрээний Эрдэнэ шанзудба Шашин төрд туслах сайдын газраар уламжлан зарлиг гуйн айлтга.²⁴ гэсэн ёсоор энэхүү асуудлыг айлтган шийдвэрлэхийн зэрэгцээ Богд хаанд хошууны засгуудаас *...сүмийг дээр өргөх ба хүн ам дагалдах шавь болох жич ном хурлыг залгамжлуулахын тул хувиас хүртсэн албыг хэлтрүүлэхийг гуйх* Мөн ...Шашин төрийн хэрэгт хаяа онц зүтгэсэн хүн нарыг зарлигаар шагнаж, хүртсэнийг аливаа улаа хэлтрүүлэх ...шавь болгохыг цөм тусгай хишгээс харах²⁵ зэрэг зүйлийг өөрийн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг байжээ. Ингэхдээ аливаа хишиг гуйхдаа харъяат хошуу засгийн газраас Чуулган даргад мэдүүлэн улмаар Эрдэнэ шанзудба Шашин төрд туслах сайдын газар ирснээр хянан үзэж зарлиг гуйн айлтган Богд хаан уг нугалбарт улаан бийрээр цохон зарлиг гуйсан ёсоор боллогтун хэмээснээр уг асуудал шийдвэрлэгдэж байжээ.

²² Дашням, Г. Монгол улсын шашин төрд туслах сайдын яам, түүний үйл ажиллагаа. - 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд лам нарын оруулсан үүтгэл үйлс. МБШТ Гандантэгчэнлин хийдээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар: 2011, 2.

²³ Дашням, Г. Мөн тэнд

²⁴ МУУТА.А-74 д-1 ХН-832, нугалбар 1

²⁵ МУУТА.А-3 д-1 ХН-324, нугалбар 20

Эрхийн хүрээнд эрхлэн шийдвэрлэж байсан албан хэргүүдээс жишээ болгон дурдvaас:

1. Хөхүүлэн шагнах талаар,

...олон хутагт хувилгааны зэрэг лам нарт гавъяа буй агаад Да ламын ямбанаас дээш хишгийг гуйваас зохих нь болвоос тогтоосон хэргийн ёсоор Эрдэнэ шанзудба Шашин төрд туслах сайдын газраас зарлиг гуйн айлтгах²⁶ гэсэн дүрэм хэмжээний дагуу олон сүм хийдийн мяндагтан лам нарт хишиг хүртээдэг байжээ.

Жишээлбэл: Шашин төрд туслах сайд, Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба, Эрхлэн зөвлөх сайд Да ламаас. Дотоод яамнаа өргөн, Нийслэл хүрээний Хамба номун хан, Эрдэнэ шанзудба, Хан Хэнтий уулын чуулган дарга нарт тушаан илгээсэн нэгэн бичигт:

...Эдүүгээ Сэцэн хан аймгийн чуулган даргын газраас ...харъяат аймгийн хурц гүн Дүдэний хошууны Дээдийн түмэн өлзий бататгах тухай ганжуур ном уншиж суух дөчөөд лам нараас тэргүүн лам хувилгаан Лувсанжамба, Дэд лам Лувсаннамдал нарт урьд хүртээсэн хишиг үгүй зэрэг учрыг гаргаж тэд нар хурал номын явдлыг сайнаар захиран гүйцэтгэж шарын шашныг өрнүүлэн зүтгэх нь үнэхээрийн сайшаалтай тул уламжлан айлтгаж хишиг шагнан хүртээвээс болох ажаамуй хэмээн мэдүүлэн ...айлтгасанд дараа 17 нд хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон зарлиг тэргүүн лам Лувсанжамбад цорж ямба, дэд лам Лувсаннамдалд хувилгаан ямба, тус тус шагнагтун²⁷ гэх мэтээр хишиг шагнал хүртээсэн олон баримтууд хадгалагдан байна.

2. Олон хошууны сүмд нэр шагнуулах,

Олноо өргөгдсөний хоёрдугаар оны \1912\ 12 сарын 26 ны нэгэн бичигт ...харъяат шавийн хувилгаан Готовдоржоос Түшээт хан аймгийн гүнгийн зэрэг ахай засаг Лувсан-ойдовын хошууны нутаг Цэцэг нуга хэмээх газар хувийн хүчээр байгуулсан сүмийг урьд нэгэнт дээр өргөж Пунцагдаржаалин хэмээх нэр шагнасан боловч басхүү нэр нэмэн шагнахыг гуйн мэдүүлж ирсэн хэргийг уламжлан Богд эзэн гэгээнээ толилон Зарлиг гуймой хэмээн айлтгасанд ...дараа 17 нд хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон зарлиг Пунцагдаржаалин сүмд Хотолыг хөгжүүлэгч нэр шагнагтун²⁸ гэх мэт

3. Шашин төрийн хэрэгт онц зүтгэсэн хүн нарыг зарлигаар шагнаж, аливаа улаа хэлтрүүлэх талаар,

²⁶ МУУТА.А-3 Д-1 ХН-324, нугалбар 20

²⁷ МУУТА.А-9 Д-1 ХН-1, 17-18

²⁸ МУУТА.А-9 Д-1 ХН-1, 19-20

...Шилийн голын чуулганы Ван Магсаржаваас Богд эзэн гэгээнээ өргөсөн Буянаар ивээгч сүмийн дэс Да лам Равжаа, Гэлэнхүү харъяат ванд үнэхээр хүчин зүтгэсэн учир уламжлан айлтгаж түүний сүргээс улаа хэлтрүүлэхийг айлтгаад ёсоор болгосон²⁹

4. Богд хааны лүндэнг дээдлэх талаар,

Олноо өргөгдөсний гуравдугаар \1913\ оны нэгэн баримтаас үзвэл Богд хаанаас гаргасан нийтийг хамарсан зарлиг тушаалыг чандлан сахиулдаг байжээ. ... Эрдэнэ шанзудба Шашин төрд туслах сайд надад зарлиг байгуулсан нь шарын шашинд аливаа харштай зүйлийг цөм чангалан байцааваас зохимой. Үүнд аливаа хүн архи уухыг цаазалж иргэдийн энэ учир архи худалдаалах ... архи уух зэргээр самуурах хүн байваас харъяат олон яамны сайдуудыг хүнддэн шийтгэх, Орос этгээд архи худалдах гэмийг даруй цаазлан зогсоох³⁰

5. Шавийн асуудлыг шийдвэрлэж байсан баримтаас,

7 сарын 22-нд манай сайдуудад дээрхийн зарлиг байгуулсан нь урьд тушаалын Сэцэн ван Цэрэнсандаваас харъяат хошууны Асууд суманд байгуулсан Өлзий бадруулагч сүм хурлыг шавийн харъяанд болгож өргөсөн нь одоо тушаалын Сэцэн ван Гомбосүрэн дээд үеийн санааг үгүйсгэж мөнхүү сүм ба харъяат сүмийн хар, шар олныг зүйл зүйлээр дарлан зовоосон учирт Гомбосүрэнг засгаас огцоруулваас зохив ч энэ удаа өршөөн хэлтэрүүлж Асууд сумын лам нар тайж түшмэд нарыг бүрэн харъяат сүмийг дагалдуулан шавьд захируулж дарлагдлаас ангижруулан миний шавь боолчуудыг нүүлгэн өршөөх туйлын таалалд нийцүүлэгтүн хэмээснийг хичээнгүйлэн дагаж үүнийг Хан Хэнтий уулын чуулган дарга жанжин нарт тушаан явуулаад харъяат хошуунд ухуулан тушааж уг байгуулсан зарлигийг хичээнгүйлэн дагаж шийтгүүлсүгэй. Үүнийг Нийслэл Хүрээний Хамба Номун Хан, Эрдэнэ шанзудба нарт тушаан явуулаад харъяат шавь захируулсан Асууд сумын тайж түшмэд ардын ам өрхийг байцаалгаж дансанд оруулах зэргээр гүйцэтгэн шийтгүүлмөй³¹ Энэхүү баримтаас шавийн асуудлаар маргаан гарваас дээрх сайдын газар шийтгээж байсан нь харагдахын зэрэгцээгээр урд нь шавьд өргөсөн зүйлээ эргүүлэн авах гэсэн ноёд ч бас гарч байжээ.

Шавьд холбогдох асуудлыг хэрхэн шийдэж байсан өөр нэг жишээ,

...Шашин Төрд Туслах Сайд надад Дээрхийн зарлиг байгуулсан нь харъяат шавийн яамнаа мөн үүнд Их сангийн зэрэг газрын алба хааж явах алба тушаалын

²⁹ МУУТА.А-9 Д-1 ХН-3, нугалбар 76

³⁰ МУУТА.А-9 Д-1 ХН-33, нугалбар 4

³¹ МУУТА.А-9 Д-1 ХН-4, 123-124

хүн нарыг Бүгд Ерөнхийлөн Захирах зэрэг 6 яамны газар дураар элдэв алба хаалгаж явуулваас болох үгүй хэрэв эрх биш алба хаалгаваас зохих учир ялгавартай буй аваас тухай бүр нэр зэргийг тодорхойлон айлтгаж тогтоолговоос зохимой³² гэх мэт шашин сүм хийдтэй холбоотой олон хэргүүдийг эрхлэн шийдвэрлэж Богд хааны гаргасан лүндэн зарлигуудыг олон яамдад түгээх олон нийтийн хүртээл болгох ажлуудыг хийдэг байжээ. Дээрх баримтуудаас хархад Их шавьд холбогдолтой асуудлуудыг шашныхны эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг байсан нь тодорхой харагдаж байна.

Төрийн хэргийн хувьд тус яам нь дотроо хэлтэс тасаг болж ямар нэг тусгай салбар асуудлыг дагнан хариуцаж байсангүй. Харин төрийн яамдын ажилтай танилцан, санал солилцож, улс төрд холбогдох асуудлаар өөрийн саналыг Богд хаанд шууд айлтгах мөн засгийн газар дахь ноёдын үйл ажиллагааг хянадаг байсан байна. Хар ноёдын үйл ажиллагаанд хяналт тавьж шийтгэсэн тухай өмнөх судлаачдын бүтээлүүдэд³³ тодорхой бий тул энд нэгэн шинэ жишээг авлаа. ...Хамба номун ханд зүй бус үг хэлсэн сайд чуулган дарга Сэцэн ван Гомбосүрэнг буруушаан шийтгэх явдлыг айлтгаад зарлиг ёсоор болгуулсан³⁴ мөн ...Сэцэн ван Цэрэнсандаваас харъяат хошууны Асууд суманд байгуулсан Өлзий бадруулагч сүм хурлыг шавийн харъяанд болгож өргөсөн нь одоо тушаалын Сэцэн ван Гомбосүрэн дээд үеийн санааг үгүйсгэж мөнхүү сүм ба харъяат сүмийн хар шар олныг зүйл зүйлээр дарлан зовоосон учирт Гомбосүрэнг засгаас огцруулваас зохив ч энэ удаа өршөөн хэлтрүүлж³⁵ хэмээсэн баримтууд байгаагаас тодорхой байна. Эхний баримтанд нэр гарч буй ван Гомбосүрэн бол 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үйл хэрэгт оролцож Халхын Хүрээний бүх хэргийг түр захиран шийтгэх газрын 7 гишүүний нэг, Чингисийн алтан ургийн засаг ноён юм. Шашин төрд туслах сайд түүнд хатуурхаж, засгаас огцруулах санал оруулахад Гомбосүрэнгийн гавъяаг бодолцон энэ удаад өршөөн хэлтрүүлсэн бололтой. Эл хэргийн дараа түүний нэр улс төрд огт дурьдагдахгүй болсон байдаг бөгөөд тэрээр Хүрээнээс одож, хошуу нутагтаа суусан бололтой байдаг.

³² МУУТА.А-9 Д-1 ХН-4, нугалбар 15

³³ Дашням, Г. Монгол улсын шашин төрд туслах сайдын яам, түүний үйл ажиллагаа. - 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд лам нарын оруулсан үүтгэл үйлс. *МБШТ Гандантэгчэнлин хийдээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл*. Улаанбаатар: 2011; Р.Төрбат Монгол улсын Шашин төрд туслах сайдын яамны түүхийн асуудалд. *Acta historica*, XVI. F.11. 2015 гэх мэт.

³⁴ МУУТА.А-9 Д-1, ХН-4, 51.

³⁵ МУУТА.А-9 Д-1, ХН-4, 123-124.

Шашин төрд туслах сайдуудаас эрхлэн шийдвэрлэж байсан асуудлыг 1913 оны хуулга дансуудаар жишээ болгон үзвэл.

Олноо өргөгдсөн гуравдугаар оны хавар, зун, намар олон газруудаас ирсэн 85 баримтыг ангилан үзэж тоогоор илэрхийлвээс,³⁶

- Сүмийн хэргэмтэн нарт хишиг хүртэх хэмээсэн 19 баримт
- Сүм хийдэд нэр шагнуулах 7
- Сүм хийдийг сэргээн засах тухай 1
- Олон хутагтуудын шавьтай холбоотой 11
- Олон газрын сүм хийд хуврага нарын тухай 12
- Хутагт хувилгаад хэргэмтэн лам нартай холбоотой 4
- Шашны хурал номын тухай 2
- Ёс суртахуунтай холбогдох 4
- Хөрөнгө улаанаас хэлтрүүлэх 2 гэх мэтчилэн үзсэн 85 баримтын 62 баримт нь сүм хийд, хутагт хувилгаадтай холбоотой байна.

Төрийн яамдаас ирсэн бичгүүд нь:

- Яамдын сайд нар халагдах, солигдох, чөлөө авах тухай 17
- Ноёдод зэрэг хэргэм нэмэх 2
- Олон улсын асуудалтай 1
- Орос сайд ирсэн 1
- Гааль худалдаа 2 зэрэг нийтдээ 23 баримт байна.

Харин Олноо өргөгдсөний 3 оны \1913\ хавар Шашин төрд туслах сайдуудын хүрээнд эрхлэн шийдвэрлэж олон газар явуулсан бичгүүдэд³⁷

- Сүм хийдийн хэргэмтэн лам нарт ямба хишиг шагнасан 20
- Сүм хийдэд нэр айлтгасан 12
- Олон хутагтын шавийн болон ном хурлын асуудлаар хэлэлцсэн 19
- Их шавийн асуудал 2, Түмэн гэлэнгийн хайлаан хуруулах асуудал 1, Шашин төрд туслах сайдын газрын ажиллагсдын асуудлаар 3, улаа хэлтрүүлэх 2, магад гарах тэмдэгт бичгийн тухай 2, аюул осол 1, ёс суртахуун 1, сайд чуулган дарга Сэцэн ван Гомбосүрэнг шийтгэсэн тухай зэрэг асуудлуудыг шийдвэрлэн гаргасан байна.

Ингээд дээрх бүхнээс үзэхэд эрхлэн шийдвэрлэсэн асуудлуудын ихэнх хувь нь шашин сүм хийд, шавь нартай холбоотой байх бөгөөд ирсэн өргөдөл гомдлын дагуу асуудлыг тавин шийдвэрлүүлж байснаас бус өөрөөр тус сайдын газраас улс

³⁶ МУУТА.А-9 Д-1, ХН-3

³⁷ МУУТА.А-9, Д-1, ХН-4

төрд холбогдол бүхий дорвитойхон санаачлан дэвшүүлэн дээш өргөж шийдүүлж байсан баримтууд Архиваас олж үзсэнгүй.

Гагцхүү шар ноёдын эрх ямба, сүр хүчийг нэмэгдүүлэх тал дээр илүү санаачлагатай ажиллаж байсан болов уу. 1915 оны Шашин төрд туслах сайдын баримтуудад: “... дэд сайд ван лам Да үзэв”³⁸ гэсэн баримтаас харахад да лам Дашжавд “ван” хэргэм хүртээсэн нь харагдаж байна. Анх тулгар төрийг байгуулж Богд хааны хишиг тархаах лүндэн буухад хар ноёдуудын хэргэм, зэргийг дээшлүүлэх талаар заасан байдаг бөгөөд харин шар ноёдуудад шашны мяндагтны ямба, цол чимэг олгохоор заасан байдаг билээ. Харин шар ноёдод хар ноёдын нэгэн адил хэргэм зэрэг олгох журмыг тус сайдын газраас санаачлан, өргөн барьж шийтгүүлсэн болов уу хэмээн төсөөлж байна. Гэхдээ яг хэзээ, ямар шийдвэрээр тийнхүү шар ноёдод хэргэм, зэрэг олгох болсонг илтгэх эх сурвалжийг судлаачид одоогоор олж үзээгүй байна.

“Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” гэх Монгол улсын гол хууль батлагдахаас өмнө 1913-1915 онуудад боловсруулан мөрдөж байсан “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм”³⁹-ийн Хоёрдугаар зүйлд буй: Харъяат шавийн яам, мөн үүдний Их сангийн зэрэг газрын албан хаах тушаалын хүн нараас дураар олон яамнаа алба хаалгаж болохгүй, хэрэв хаалгаваас зохих учир ялгавартай нь аваас тухай бүр нэр зэргийг тодорхойлон айлтгаж тогтоолгох тухай дүрмийг Олноо өргөгдсөний 3 дугаар онд \1913\ батлан гарсан байхыг үзвээс эл асуудлыг Шашин төрд туслах сайдуудаас боловсруулан оруулсан байх магадлалтай бөгөөд тус заалт нь шашныхан төрийн бүх шатны ажилд оролцох явдлыг хязгаарлаж байсан нь харагдана.

Олон түмнийг хамарсан томоохон хурал ном зан үйл, хутагтад бат оршил өргөх, уул овоо тахих зэрэг олон үйлүүдийн зардал хэрэглэлийг өмнө нь Их сан болон дөрвөн аймгаас нийгэмчлэн гаргадаг байв. Живзундамба хутагт Монгол улсын хаан болсоноор хааны зоог хүнс, шашны зарим нэг хурал номыг улсын чанартай болгож Шашин төрд туслах сайдаар дамжуулан эдгээр зан үйлүүдийн зардал хэрэглэлийг хэрхэн яаж зохицуулж болохыг Улсын Дээд Доод хуралд санал оруулан батлуулж байсан байна. Энд Доод хурлаас Нийслэл хүрээний газар Түмэн гэлэнгийн хайлаан хурах олон яамдаас гаргасан сайд түшмэд хэлэлцэн төлөвлөснийг ... Дээд хурал үзэж олон яамны сайд түшмэдийн төлөвлөсөн ба

³⁸ МУУТА. А-9, Д-1, ХН-88, А-9, нугалбар 38

³⁹ *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм*. 1913-1918. Эх бичгийн судалгаа. Ж.Урангуа, Б.Баярсайхан. Улаанбаатар: 2004, 55.

Доод хурлыг цохсон ... энэ жил хайлаан хурлын бүх 45 өдрийг 6% бодож 2%-ийг улсын сан, Их шавь 2 газраас гаргуулан үлдсэн хувийг хуучин удаагаар хувь тоонд онуулан өөр өөрийн оноосон өдөр хоногт тус бүр сайд ноёд түшмэдийг томилон даалгаж бүх хэрэгсэлийг бүрэн бүртгэн нийлүүлж уг хурал номыг гүйцэлдүүлэх,⁴⁰ Мөн эзний зоог тахилын хэрэглэлийг улсын сангаас хувь зохион гаргуулах гэх асуудлуудыг Улсын Дээд, Доод хурлаар оруулан шийдвэрлүүлж байжээ.

Шашин төрд туслах сайдуудын газрыг татан буулгасан нь

1915 онд Орос-Монгол-Хятад гурван этгээдийн Хиагтын гэрээгээр Монгол улсыг Хятадын эзэн эрхийн дор автономит эрхтэй орших улс болгон бүрэн эрхт байдлыг хязгаарласны дараа Улсын төсөв мөнгийг хэмнэх үүднээс зарим нэгэн арга хэмжээг авсан байна.

Манжийн эрхшээлийн үед өөрийн засгийн газаргүй, төвлөрсөн санхүүгүй байсан билээ. Шинэ тулгар төрөө байгуулсан Монгол улс нь санхүү эдийн засгийн хувьд хүнд хэцүү байсан юм. Гадны туслалцаа дэмжлэг хэрэгцээтэй байсан юм. 1911 оны эцсээр ...Халхаас Дайчин улсын банкинд төлөх өр 800 мянга гаруй лан мөнгө⁴¹ байсан бөгөөд өр нэхэгдсээр байв. Улсынхаа тусгаар болсон явдлыг баталгаажуулахад, эдийн засгаа өөд татан улс орноо хөгжүүлэхэд мөнгөний хэрэгцээ их байв. Тиймээс Хаант Орос улсаас удаа дараа зээл авч байлаа. Улсын орлого зарлагаа нөхөж чадахгүй байлаа. Өөрсдөө мөнгө санхүүгийн гачигдалд байсан хэдүйч Засгийн газар элэг нэгт Өвөрмонголчуудаас Хятадын эсрэг хийж байсан тэмцлийг дэмжиж, тэдэнд зүйл бүрийн туслалцаа үзүүлж байсан юм.

Улсын төсөв мөнгө 1911-1919 онд байнга алдагдалтай байсан тухай түүхч З. Лонжид төрийн албан хаагчдад олгож байсан цалингаар жишээ аван бичжээ. Тухайлбал ... Богд эзэн, Улсын эх дагина нар тус бүр жилд 36000 лан мөнгө, ерөнхий сайд Намнансүрэн 5000 лан, Халхын дөрвөн хан 5 хүнд 2500 лан, төрийн таван яамны тэргүүн сайд нар 205 лан, дэд сайд 14 хүн 162 лан 5 цэн ...ван гүнгүүдэд олгох цалин Ханддоржид 4000 лан, Чин ванд 2000 лан, Жүн ванд 1200 лан, Бэйлд 800, Бэйс 500 лан, Улсын түшээ гүнд 300 лан, Улсад туслагч гүнд 200 лан, Засаг тэргүүн зэрэг тайжид 100 лан⁴² гэх мэтээр олон яамдын түшмэд нарт улсын сангаас цалин олгож байсан тухай баримтуудыг дурьдсанаас

⁴⁰ МУУТА.А-1, Д-1, ХН-1

⁴¹ Лонжид З. *Монгол улсын санхүүгийн албаны түүх* (1911-1921). Улаанбаатар: 2000, 20.

⁴² Мөн тэнд, 24

үзэхэд төрийн нүсэр аппаратын зардалд үлэмжхэн хэмжээний мөнгө зарцуулагдаж байжээ. Мөн 1913-1914 онд явуулсан Өвөр Монголын чөлөөх 5 замын байлдаан ч улсын санхүү эдийн засагт хүнд дарамт болсон зэрэг дээрх олон шалтгаануудын улмаас улсын төсөвийг хэмнэх нэрийн дор авсан арга хэмжээний хүрээнд 1912 онд байгуулагдсан гурван яамыг татан буулгахад Шашин төрд туслах сайдын газар хамаарагдсан юм.

Шашин төрд туслах сайдын газрыг татан буулгаж, Шашны хэргийг хамба мэтийн эрх тушаал бүхий лам нар захиран шийтгүүлж мөн Дотоод яамнаа Ерөнхийлөн захируулах ⁴³болсон байна. Үүний дагуу Эрдэнэ шанзудба яамнаас Шашин төрд туслах яамыг хасаж тамгын хураалгах зэргээр гүйцэтгэн шийтгүүлмөй гэсэн нэгэн бичигт ...Шашин төрд туслах яамны буй бүхий данс бичгийг тухайн эрхэлсэн түшмэл бичээчид тушааж томилуулан бүртгэж шийтгэн дуусгатуй ...мөнхүү Шашин төрд туслах сайдын тамга ба уг данс бичгийн хамт түшмэл зайсан Базар нарт тушаан явуулан авахуулан хүргүүлсэн явдлыг Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх яамнаа өргөв⁴⁴ хэмээгээд ...Шашин төрд туслах сайдуудын яам анх байгуулсан Олноо өргөгдсөний 2 оны \1912\ намар цагаас нааш энэ жил есөн сар хүртэл олон газраас ирсэн мэдүүлсэн бичиг 692, тусгай зохиосон ба эх сүүл залгасантай хамт эх бүгд 258 бас хууль зохиож бүхий газар түшмэл зайсан Магсаржавын авчирсан бичиг 1, эх гурав, айлтгасан нугалбар 123 зүйл хуудас 16, боодол 89 ирсэн явуулсан бичгийн хуудас өдрийн тэмдэглэл хуулга бүхий 15 дэвтэр мөн олон яамны зэрэг газар харилцан зөвлөлдсөн хуудас 1 бүстэй, бас хүрээ Гандан хийдийн нутгийн зураг 1, тойрон байгуулсан банз модыг өдөр бүр байцаалгаж тэдний нэр зэргийг тэмдэглэсэн хуудсуудын хамт нэг боодолтой болохын дотроос гарган шийтгэн тогтоосон орд сүмийн үйлдвэрт тусалсан мөнгөний тухай хэрэг 1 бүстэй, бас засаг мөшгөгдөв хэмээн тэмцсэн Цорж ямба Лувсанжанцаны хэрэг нэг бүстэй бас тойн Дагвадорж нарын адуу залилсан банди Жанцаны хэрэг 1 бүстэй⁴⁵ гэх мэт олон баримтуудыг Олноо өргөгдсөний 5 оны \1915\ 9 сарын 12 нд тодорхойлон шилжүүлсэн байна. Бүгд ерөнхийлөн захирах, Шашин төрд туслах сайд хоёр яамны шийтгэн тасалсан ба таслаагүй хэргийн данс бичгийг тус тус Дотоод яамнаа шилжүүлэн хүргүүлж ирснийг хүлээн авч тамга данс бичгийг хураан хадгалсан ба мөнхүү хоёр яамны шийтгэн дуусгаагүй хэрэг зүйлийг манай Дотоод яамнаа эрхлэн шийтгэнэ⁴⁶ хэмээсэн ёсоор тус сайдын газар эрхлэн бүхий

⁴³ МУУТА.А-3 Д-1 ХН-639, нугалбар 1

⁴⁴ МУУТА.А-3 Д-1 ХН-639, нугалбар 14

⁴⁵ МУУТА.А-3 Д-1 ХН-639, нугалбар 14

⁴⁶ МУУТА.А-3 Д-1 ХН-639, нугалбар 2

тамга тэмдэг бусад албан бичгүүдээ Дотоод яамнаа шилжүүлснээр үйл ажиллагаа нь зогссон байна. Тийнхүү төсөв мөнгө хэмнэх нь зүйн хэрэг байсны нөгөөтэйгүүр уул сайдын газрын улс төр болон нийгмийн үйл ажиллагааны чиглэл болон үр дүн нь төдийлөн үр ашигтай бус, тус институцыг цаашид байлгах нийгмийн хэрэгцээ байгаагүйтэй холбоотой байсан гэж үзэж болохоор байна. Нөгөө талаар шашны өндөр мяндагтнууд Монголын төрд эзлэх байр суурь, эрх дархыг тус сайдын газар оршин тогтнох хугацаандаа бүрэн гүйцэлдүүлж чадсан гэлтэй.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлын үр дүнд би судлагдахууныхаа талаар дараах түүхэн дүр зургийг гаргаж байна.

Төрийн тусгаар тогтнолоо олж авсан монголчууд шинэ тулгар төрөө эмхлэн зохион байгуулахдаа тухайн үеийн боловсон улс түмнүүдийн төрийн бүтцийг нарийвчлан судлан үзэж анх 5 яам бүхий газрын газрыг буй болгож, улмаар төрийн бүтцээ төгөлдөржүүлэх алхмуудыг хийж байжээ. Гэвч тус оронд тогтсон засаглалын хэлбэртэй холбоотойгоор тухайлбал, төрийн тэргүүний сэнтийд Монголын бурхан шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагт заларсантай холбоотойгоор тус орны улс төрийн амьдралд шашныхны нөлөө их болж, төрийн өндөр албан тушаалд томилогдон төрийн хэрэгт оролцох болжээ. Улмаар шар ноёдын дуу хоолойг улс төрд хүргэх, улс орны холбогдол бүхий хэргүүдийг хэлэлцэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх үүднээс 1912 оны эцсээр Шашин, төрд туслах сайдуудын орон тоог буй болгож, тэдний ажлын албыг эмхлэн зохион байгуулсан ба Улсын Дээд хуралд шашны өндөр албан тушаалтнуудыг суулгах болжээ.

Шашин төрд туслах сайдын газар нь яамны зиндаанд хүрэхүйц орон тоо, бүтэц үгүй бөгөөд түүнд онцгойлон хамаарч эрхлэх салбар байсангүй, гагцхүү урдын адил Эрдэнэ шанзудбагийн алба ерөнхийдөө шашны хэргийг эрхлэх боловч шашны зарим хэргийг Дотоод яам бас хариуцаж байсан байна. Тус газрын статусыг авч үзвээс Богд хаан өөрийн мэдлийн Их шавийн хамаг хэргийг эрхлэн шийтгэх Эрдэнэ шанзудбын яамыг хэрэг дээрээ Монголын шашны асуудлыг эрхлэн мэдэх төвлөрсөн байгуулга болгон өргөжүүлж, шашны асуудлуудыг хаанд эрхэмлэн айлтгахын сацуу төрд зөвлөх эрхтэй байгууллыг шинээр бий болгосон явдал байжээ.

Их Хүрээний Эрдэнэ шанзудбын яамыг түшиглэн байгуулагдсан энэхүү сайдын газар Монголын шашны асуудлыг ерөнхийд нь эрхлэн мэдэх байгууллага болсон хэдий ч Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яам болон Бүгд Ерөнхийлөн Захирах яамтай хамтран Монголын шашны асуудлыг хамтатган мэдэж байсан нь архивт хадгалагдан буй баримтуудаас тодорхой байна. Ерөнхийд нь үйл ажиллагааны чиглэлийг нь шашны болон төрийн хэмээн хувааж үзэхэд шашны талын үйл ажиллагаа нь давамгайлж байна. Гэхдээ төрийн өндөр албан тушаалд өндөр мяндагтнууд томилогдох, тэдэнд хар ноёдын нэгэн адил хэргэм, зэрэг олгох явдлыг журамлан тогтоосны зэрэгцээгээр шашныхан төрийн хэрэгт олноороо орж оролцох явдлыг хязгаарласан тал бас үзэгдэнэ. Хар ноёдын зүгээс шар ноёдуудад тааламжгүй хандах аливаа үзэгдлийг таслан зогсоох тал дээр хатуу байр суурь баримталж байжээ.

Хиагтын гурван улсын гэрээгээр Олноо өргөгдсөн Монгол улсыг Хятадын эзэн эрхийн дор орших автономит засагтай улс болгон хувиргасны дараа тус орны төсөв мөнгийг хэмнэх үүднээс Шашин төрд туслах сайдын газрыг татан буулгасан нь тус институцыг цаашид байлгах нийгмийн хэрэгцээ байгаагүйтэй холбоотой байсан гэж үзэж байна. Нөгөө талаар шашны өндөр мяндагтнууд Монголын төрд эзлэх байр суурь, эрх дархыг тус сайдын газар оршин тогтнох хугацаанд бүрэн гүйцэлдүүлж чадсан гэлтэй.

Эцэст нь цохон тэмдэглэхэд Монголын шарын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагт Монголын хаан болсноор түүний харъяат Эрдэнэ шанзудбын яам нь Монголын шашны асуудлыг эрхэлсэн, төрд зөвлөх эрхтэй байгуулга болон ажилласан ч богино настай байжээ. Гэсэн хэдий ч дээд лам нарын эрх байр суурь хумигдсан зүйл үгүй, төрийн яамдын өндөр албан тушаалуудыг үргэлжлүүлэн 1924 он хүртэл хашиж байсан байна.

Abstract: In 1911, Mongolia has regained and declared its state independence and proclaimed VIII Bogd Jivzundamba noble as a khan for ruling the both state and religion, also was established a government with five ministries. Government structure was expanded in 1912 and was created three more ministries, one of which was the Ministry of Assistance to the State and Religion. Although there are assumptions and other notifications of researchers about the reasons for the creation of the Ministry of Assistance to the State and Religion, there is still no thorough study of this institution status, such as whether it was the Ministry, as well

as what were the activities, rights and responsibilities, what the relationship with the Ministry of the Great students Shanzudba. Therefore, this article is aiming to clarify and discover the reasons for the creation and liquidation of the Ministry of Assistance to the State and Religion, its rights and obligations. For this end, we used sources and documents of the Ministry of Assistance to the State and Religion and other ministries that are stored in the National Archives of Mongolia.